



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/415

Улаанбаатар хот

Нийтийн эзэмшлийн зам тайлбайд
ил задгай сүү, цагаан идээ, хүнсний ногооны
худалдаа эрхэлж буй иргэдийн үйл ажиллагаанд
хяналт шалгалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 3.2, 6.17 дугаар зүйлийн 7, 10.4 дүгээр зүйлийн 1, 13.4 дүгээр зүйлийн 2.3, 15.2 дугаар зүйлийн 1.1, 2.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаал Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт MNTR2:2011 стандартыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн 1, 3, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайд гар дээрээс ил задгай зөвшөөрөлгүй, сүү, цагаан идээ, хүнсний ногооны худалдаа эрхэлж байгаа иргэдийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг 2019 оны 08 дугаар сарын 05-наас 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Баянгол дүүргийн 1, 3, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт ил задгай сүү, цагаан идээ, хүнсний ногооны худалдаа эрхэлж байгаа иргэдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан байдал, мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ, түүний баталгаажилтанд хяналт хийх, бүтээгдэхүүнээс сорьц дээж авч, лабораторийн шинжилгээнд хамруулах, орчны хөрсний бохирдолд дээж авч үнэлэлт өгөх, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй эсэхэд хамтарсан хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, хуулийн хариуцлага хүлээлгэх ажлыг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэхийг ажлын хэсэгт даалгасугай.

3. Хяналт шалгалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийг нэгдүгээр, орчны удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Тухайн орчны 2 цэгээс хөрсний дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулахад шаардагдах 120,000 /нэг зуун хорин мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ахлах нягтлан бодогч /Б.Хонгорзул/-д зөвшөөрсүгэй.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хийгдсэн ажлын үр дүнг танилцуулахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

Баянгол дүүргийн Засаг даргын
2019 оны .08. дугаар сарын 05.-ны өдрийн
А/415 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
дарга:

Э.Батбилэг

Эдийн засаг, худалдаа үйлчилгээ,
тохижилт, нийтийн аж ахуйн асуудал
хариуцсан төслийн удирдагч

Гишүүд:

Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн
хяналтын хэлтэс

Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс

Цагдаагийн 1 дүгээр хэлтэс

Цагдаагийн 2 дугаар хэлтэс

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс


Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ

Баянгол дүүргийн Комлуу мал
эмнэлэг, үйлчилгээний нэгж

Баянгол дүүргийн 1, 3, 4 дүгээр
хорооны Засаг дарга, зохион
байгуулагч

Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн
төлөө газрын Улсын байцаагч

Баянгол дүүргийн Засаг даргын
2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн
А/115 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЗАМ ТАЛБАЙД ИЛ ЗАДГАЙ СҮҮ, ЦАГААН
ИДЭЭНИЙ ХУДАЛДАА ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго:

Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайд гар дээрээс ил задгай сүү, цагаан идээний худалдаа эрхэлж иргэдийн амь нас, эрүүл мэнд болон орчны бохирдолд үүсгэж буй байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэн иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боллоцоог хангах зорилготой.

Хоёр. Хамрах хүрээ:

Ил задгай худалдаа эрхэлж буй иргэдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан эсэх, худалдаалж буй сүүнээс дээж авч, чанар аюулгүй байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, сүүний мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээний баталгаажилт, сүү, цагаан идээний хадгалат, тээвэрлэлт, түгээлтийн байдал, хуванцар савны хэрэглээ, хөрснөөс дээж авч, орчны эрүүл ахуйн нөхцөлд үнэлэлт өгөх

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа:

2019 оны 08 дугаар сарын 05-наас 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдөр хүртэл

Дөрөв. Хяналт, шалгалт хийх үндсэн чиглэл:

Нийтийн эзэмшлийн зам талбайд сүү, цагаан идээний худалдаа эрхэлж буй иргэдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж, сорьц дээж авч, үнэлэлт дүгнэлт өгөх, зөрчлийг таслан зогсоож хуулийн хариуцлага хүлээлгэх, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах

Тав. Хяналт шалгалтын дүн мэдээг тайлагнах:

2019 оны 08 дугаар сарын 08-ны өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүн хийж гүйцэтгэсэн ажлын дүн мэдээг Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст ирүүлэх, нэгтгэж Засаг даргын Тамгын газарт тайлан мэдээг хүргүүлж ажиллана.

Баянгол дүүргийн Засаг даргын
2019 оны .08 дугаар сарын .05 ны өдрийн
А/415 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Бүтээгдэхүүн	Тоо хэмжээ	Үнэ
1	Хөрсний шинжилгээний төлбөр	2	120,000
	Нийт дүн		120,000